


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

09.21 - 09.25



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудаас бүрддэг индексүүд дөрөвдөх долоо хоногтоо дараалан буурсан нь энэ жилийн хамгийн урт хугацааны уналт байсан ба S&P 500 индекс энэ оны дээд үеэсээ 10%-аас илүү хувиар буурсан байна. Өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний салбар хамгийн их өсөлттэй байсан нь Nike компанийн сүүлийн тайланд зуны борлуулалт эргэн сэргэсэнээр тус компанийн хувьцааны ханш өссөнтэй холбоотой байлаа. Мөн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ханш өсөлттэй байснаар технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq индекс өсөлттэй хаагдлаа. Газрын тос болон байгалийн хийн үнэ уналттай байгаатай холбоотой S&P 500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбарын компаниуд хамгийн их уналттай байсан ба зарим бүсийн арилжааны банкнуудын зээл олголтын хэмжээ муу байгаатай холбоотой санхүүгийн салбар мөн уналттай байлаа.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт уналттай хаагдлаа. Энэхүү уналт нь коронавирусын шинэ тохиолдлууд огцом нэмэгдэн зарим улс орнуудыг халдварын тархалтыг хязгаарлахын тулд илүү хатуу арга хэмжээ авахад хүргэсэн болон эдийн засгийн сэргэлт зогсонги байдалд орох төлөвтэй байгаатай холбоотой байлаа. STOXX Europe 600 индекс 3.60%-аар, DAX индекс 4.93%-аар, CAC 40 индекс 4.99%-аар, FTSE MIB 4.23%-аар, FTSE 100 индекс 2.74%-аар тус тус буурсан байна.

Олныг хамарсан коронавирусын тархалтыг давтахгүй байх "сүүлийн боломж" тулгарч байна гэж Европын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын комиссар Стелла Кириакидес анхааруулав. Тэрээр Европын Холбооны бүх гишүүн орнуудыг халдварыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд бэлэн байхыг уриалав. Одоогоор Франц, Испани, Их Британи болон ХБНГУ-аас халдварын хоёр дахь давлагааг зогсоох зорилготой нэмэлт арга хэмжээ аваад байна.

Япон: Баярын өдөр таарсантай холбоотой арилжааны өдөр цөөхөн байсан энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа. Даваа болон Мягмар гарагуудад өндөр настны өдөр болон өдөр шөнө тэнцэж буй өдөр тус тус таарсантай холбоотой япон улсын хөрөнгийн зах зээл хаалттай байжээ. Nikkei 225 индекс 156 нэгжээр буюу 0.49%-аар буурч 23,204.62 нэгж дээр хаагдсан нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 1.9%-ийн бууралт юм. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэх large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн бууралттай хаагджээ. Энэ долоо хоногт иений ханш харьцангуй тогтмол байсан ба Баасан гарагт 1 ам.доллар 105 иенээс илүү ханшаар арилжаалагдсан байна.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дэлхийн бусад томоохон индексүүдийн адилаар уналттай хаагдлаа. Shanghai Composite индекс болон CSI 300 индекс тус тус 3.6%-аар болон 3.5%-аар буурсан нь 7-р сарын дунд үеийн зах зээлийн уналтаас их байв. Бондын зах зээл дээр БНХАУ-ын 10 жилийн хугацаатай гадаад зах зээлд гаргасан ЗГҮЦ-ны өгөөж 3 нэгж бууран 3.13% хүрсэн байна. Харин БНХАУ-ын Төв банкнаас шинжээчдийн хүлээж байсны дагуу бодлогын хүүгээ тавдагч сардаа дараалан хэвээр үлдээлээ. Ам.долларын эсрэг юанийн ханш сулран 6.82 юань хүрлээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,569.04	1.09% ▲
Dow Jones	АНУ	27,173.96	-1.75% ▼
S&P 500	АНУ	3,298.46	-0.63% ▼
Nasdaq	АНУ	10,913.56	1.11% ▲
S&P/TSX	Канад	16,065.35	-0.82% ▼
FTSE 100	Их Британи	5,842.67	-2.74% ▼
S&P/ASX 200	Австрали	5,964.90	1.71% ▲
Nikkei 225	Япон	23,204.62	-0.49% ▼
Hang Seng	Хонг Конг	23,235.42	-4.99% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.95
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.02
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.43
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.36
DBM' 2023	USD	7.250%	105.09
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.92

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.146	-0.06 ▼
Libor 3M	0.218	-0.03 ▼
Libor 6M	0.271	-0.01 ▼
Libor 1YR	0.369	-0.01 ▼
US 2YR Bond	0.131	-0.06 ▼
US 3YR Bond	0.151	-0.06 ▼
US 5YR Bond	0.267	-0.05 ▼
US 10YR Bond	0.658	-0.05 ▼

Валютын ханш	2020.09.25	Өөрчлөлт
USD	2,853.64	-0.02% ▼
CNY	418.71	-0.84% ▼
EUR	3,332.48	-1.46% ▼
RUB	37.15	-2.31% ▼
KRW	2.44	-0.81% ▼
JPY	27.08	-0.77% ▼
CAD	2,136.28	-1.48% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,861.58	-4.58% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	22.89	-14.55% ▼
Зэс	USD/lb.	297.10	-4.65% ▼
Нүүрс	USD/MT	60.13	1.74% ▲
WTI газрын тос	USD/bbl.	40.25	-2.09% ▼
Brent газрын тос	USD/bbl.	41.92	-2.85% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.14	4.39% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VIII	2.10%
Бодлогын хүү	2020.VIII	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VIII	8.73%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	10.84%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VIII	4.13%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	16.93%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VIII	10.44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 54 компанийн 664.6 сая төгрөгийн 6,049,894 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Жуулчин говь” /MSE: JGV/ компанийн хувьцаа 31.64%-аар буюу хамгийн ихээр өсөж 10,400.00 төгрөг хүрч хаагдсан бол “Баянгол зочид буудал” /MSE: BNG/ компанийн хувьцаа 12.98%-аар буурч 25,060.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 1.0 сая төгрөгийн 10 ширхэг үнэт цаас арилжаалагдав


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

9-р сарын 25-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,609.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,569.04 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.09% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	10	1,000,600	100,200	101,000	52	17%

Зах зээлийн тойм

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	664.6
Зах зээлийн үнэлгээ	2,609,668.4

Зах зээлийн индексүүд

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,569.04	1.09% ▲
MSE I индекс	8,305.06	0.05% ▲
MSE II индекс	7,508.04	1.11% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Женко тур бюро	4,705,921	447,062,495
Ард санхүүгийн нэгдэл	33,220	43,555,099
АПУ	46,613	26,472,014
Эрдэнэ ресурс девелопмент корп	23,026	19,922,504
Инвекор ББСБ	6,120	16,387,342

Өсөлттэй хувьцаа

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Жуулчин говь	10,400.00	31.64% ▲
Стандарт агрикалчер групп	80.00	17.64% ▲
Силк нет	828.00	15.00% ▲
Мон наб	5,175.00	15.00% ▲
Автоимпекс	1,184.00	14.95% ▲

Бууралттай хувьцаа

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол зочид буудал	25,060.00	-12.98% ▼
Монгол савхи	480.00	-12.06% ▼
Сор	575.00	-10.88% ▼
Монгол нэхмэл	1,875.00	-10.71% ▼
Оллоо	50.00	-5.90% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	990,508,591
Ард Секюритиз	79,635,172
Бумбат-Алтай	40,927,233
Гаули	36,108,109
Ти Ди Би Капитал	25,627,445

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	570.00	606,583.49
Таван толгой	5,980.00	314,937.90
МИК холдинг	12,800.00	265,079.30
Инвекор ББСБ	2,700.00	193,665.38
Говь	199.47	155,609.04

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3-р зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23-р зүйлийн 23.11 дэх заалтууд болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 8/4031, 11/3130 дугаар албан тоотуудыг тус тус үндэслэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 9-р сарын 24-ний өдрийн А/66 тоот тушаалаар Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны арилжааг нь зогсоосноос хойш дараалсан 5-аас дээш жил арилжааг сэргээгээгүй “Өргөн хэрэглээ” ХК, “Эсгий гутал” ХК болон Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй “Бороогийн үйлдвэр” ХК, “Дизель зуухны угсралт, засварын газар” ХК, “Ноёт хайрхан” ХК-ийг тус тус Монголын хөрөнгийн биржийн бүртгэлтэй хувьцаат компанийн бүртгэлээс хаслаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Тандэм инвест ББСБ” /MSE: VIK/ ХК-ийн шүүхэд хариуцагчаар оролцож байгаа тухай мэдээлэл.

Компани Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журмын 3.2-д Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна гэж заасны дагуу тус журмын 3.2.2.11-д Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцохтой холбоотой мэдээллийг үүгээр хүргүүлж байна.

Компани 2020 оны 9-р сарын 21-ны өдрийн байдлаар шүүхэд нэхэмжлэгчээр болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчаар оролцож буй мэдээлэл:

№	ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
1	ТӨЛБӨР НЭХЭМЖЛЭХ	1	38,572,127.00
2	ШҮҮХИЙН ШИЙДВЭР	3	284,961,643.00

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК-ийн шүүхэд нэхэмжлэгчээр оролцож байгаа тухай мэдээлэл.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 3.2-д “Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна” гэж заасны дагуу 3.2.2.11-д “Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох”-той холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

“Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК нь 2020 оны 8-р сарын 31-ны өдрийн байдлаарх шүүхэд нэхэмжлэгчээр оролцож байгаа мэдээлэл:

ТӨРӨЛ	ШАТ	ТОО	ҮНИЙН ДҮН
ДААТГАЛЫН БУС	ДЭЭД ШҮҮХ	2	75,345,941.00
БУРУУТАЙ ЭТГЭЭДИЙН АВЛАГА	АНХАН ШАТНЫ ШҮҮХ	23	240,246,445.25
ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН АВЛАГА	АНХАН ШАТНЫ ШҮҮХ	28	12,749,606.00
	НИЙТ	53	328,341,992.25

Шүүхэд нэхэмжлэгчээр оролцож байгаа нийт 53 нэхэмжлэл байгаагаас 51 нэхэмжлэл анхан шатны шүүх, 2 нэхэмжлэл нь дээд шатны шүүхийн шатанд байна.

Эдгээр нэхэмжлэхүүд нь шүүхийн шатанд явагдаж байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа болно

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК-ийн шүүхэд хариуцагчаар оролцож байгаа тухай мэдээлэл.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 3.2-д “Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна” гэж заасны дагуу 3.2.2.11-д “Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох”-той холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

“Мандал даатгал” /MSE: MNDL/ ХК нь 2020 оны 8-р сарын 31-ны байдлаарх шүүхэд хариуцагчаар оролцож байгаа мэдээлэл.

ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
НӨХӨН ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ	8	331,763,833.00
БУСАД	1	109,756,702.00
НИЙТ	9	441,520,535.00

Шүүхэд хариуцагчаар оролцож байгаа даатгалын 8 нэхэмжлэх, даатгалын бус 1 нэхэмжлэх байна.

Эдгээр нэхэмжлэхүүд нь шүүхийн шатанд явагдаж байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа болно.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголбанкнаас ипотекийн зээлийн хөтөлбөрийг дахин санхүүжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2020 оны 8-р сарын эцсийн байдлаар нийт 144.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2057 иргэнд олгоод байгааг мэдээллээ.

Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 71.7 тэрбум төгрөг, банкуудын өөрийн эх үүсвэрээс 73.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ. Монголбанк ипотекийн санхүүжилтийг энэ он дуустал олгоно. Харин санхүүжилтээ цааш үргэлжлүүлэх эсэх нь хууль, эрх зүйн орчноос шалтгаална гэж мэдээлсэн юм.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Цар тахлын үед эдийн засгийн голлох дөрвөн салбарт 29 мянган хүн сүүлийн зургаан сард ажлын байргүй болсон талаар Азийн хөгжлийн банкны Ахлах эдийн засагч С.Болд мэдээллээ. Хэдий тийм боловч оны эхний хагас жилийн статистикаас харвал ажилгүйдлийн түвшин 6.6 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

"COVID-19" цар тахлын улмаас хэчнээн ажлын байр үгүй болсныг албан ёсоор нэгтгэж гаргасан тоо баримт хомс байна. Хилийн хязгаарлалт тогтоосноос хойш 22 мянга 448 иргэнийг татан авчээ. Эдгээр хүмүүсийг ажилд ороогүй гэж

тооцвол ажилгүйдлийн түвшин бодитоор 8.3 орчим хувьд хүрсэн байх магадлалтай байгаа аж.

Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 16 хувь нь орлогоо алдсан, 73 хувийнх нь орлого буурсан гэж Дэлхийн банк мэдээлж байсан юм. Хэдийгээр цалинтай хөдөлмөр эрхлэгчдийн байдал "COVID-19"-ийн нөлөөлөлд харьцангуй бага өртсөн ч гурван өрх тутмын нэгийг нь цалингийн орлого буурсан гэж мэдээлээд байна. Мөн тус судалгаанд оролцсон өрхүүдийн 12 хувь нь өрхийн аль нэг гишүүн ажилгүй болсон гэж хариулжээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Жоншны экспорт биет хэмжээгээр өссөн ч мөнгөн дүнгээр буураад байна. Оны эхний найман сард Монгол Улс 427.8 мянган тонн жоншны хүдэр, баяжмалыг 101.3 сая ам.доллароор экспортолжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 1.6 хувиар өссөн ч мөнгөн дүнгээр 23.4 хувиар буурсан байна. Цар тахлын нөлөөгөөр БНХАУ-д жоншны үнэ буурсан ч ОХУ-д жижиг үйлдвэрүүдийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байсантай холбоотойгоор үнэ буураагүй, идэвхжил сэргэхтэй зэрэгцээд үнэ өсөх хандлагатай байгааг "Баялаг жонш" компанийн Ерөнхий захирал мэдээллээ.

Нийт экспортын 70 хувийг БНХАУ, 29 хувийг ОХУ-д экспортолсон байна. Түүнчлэн БНСУ болон Узбекистан руу бага хэмжээгээр экспортолжээ. Сүүлийн үед Японы хэрэглэгчид Владивостокийн боомтоор дамжуулан Монголоос жонш авах сонирхол ажиглагдаж байгаа гэдгийг "Баялаг жонш" компани мэдээллээ.

Жонш экспортлогчдын хувьд Засгийн газраас тогтоож, татвар авдаг жишиг үнэ бодит гэрээний үнээс хэт өндөр байгаад шүүмжлэлтэй хандсаар ирснийг Жоншны холбоо мэдээлж байлаа.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.